

Хөдөө аж ахуйн ур чадварын түвшин тогтоох шалгалт (Газар тариалангийн ерөнхий мэдлэг)-ын шалгалтын стандартын тойм, Монгол хэлний хэвлэл

Үндэсний Хөдөө Аж Ахуйн Танхим

Хөдөө аж ахуйн ур чадварын түвшин тогтоох шалгалтын Хэрэг эрхлэх газар

1. Шалгалтын стандарт

(1) Шалгалтын үргэлжлэх хугацаа

60 минут (Үүнээс гадна, шалгалтын зааварчилгаа, дуу шалгах дэлгэц зэрэгт 10 минут)

(2) Шалгалтын сэдэв

○ Япон хэлний чадвар шалгах, үнэлгээ хийх (Япон хэлний шалгалт)

1) Япон хэлний шалгалт

Бичлэг сонсож, тоогоор бичих хэлбэрийн болон сонгох хэлбэрийн шалгалт

○ Газар тариалангийн онолын болон практик шалгалт

1) Онолын шалгалт

Зөв бурууг олох хэлбэрийн болон сонгох хэлбэрийн шалгалт

2) Практик шалгалт

Зөв бурууг олох хэлбэрийн болон сонгох хэлбэрийн шалгалт

(3) Шалгалтын даалгаврын тоо

70 орчим асуулттай. (Зөв хариултын хувь г.м дүн шинжилгээ хийхэд ашиглагдах, шалгалтын оноонд нөлөөлөхгүй даалгавар үүнд орно.)

2. Шалгалтанд тэнцэх шалгуур

Нийт авсан оноо нь Үндэсний Хөдөө Аж Ахуйн Танхимын тогтоосон шалгуур онооноос дээш байх.

3. Тус баримт бичгийг хэрэгжүүлэх

Хөдөө аж ахуйн ур чадварын түвшин тогтоох шалгалт (Газар тариалангийн ерөнхий мэдлэг)-ын “Шалгалтын стандарт”-ыг хэрэгжүүлэхдээ, Япон хэлээр боловсруулсан эх хувийг үндэслэн хэрэгжүүлнэ.

Хөдөө аж ахуйн ур чадварын түвшин тогтоох шалгалт (Газар тариалангийн ерөнхий мэдлэг)-ын “Онолын шалгалт”-ын даалгаврын агуулгын хүрээ, Монгол хэлний хэвлэл

Үндэсний Хөдөө Аж Ахуйн Танхим

Хөдөө аж ахуйн ур чадварын түвшин тогтоох шалгалтын Хэрэг эрхлэх газар

1. Газар тариалангийн ерөнхий мэдлэг

(1) Эрхтэн бүрийн ургалт, өсөлт

Эрхтэн бүрийн ургалт, өсөлтийн тухай.

(2) Тариалах арга

Тариалах аргын талаар дараах зүйлсийн тухай.

1) Үр суулгах, 2) Үрслэг хийх, үрслэг шилжүүлэн суулгах, 3) Услах

(3) Тариалалтын хяналт

Тариалалтын хяналтын талаар дараах зүйлсийн тухай.

1) Хөрсний төрөл, 2) Хөрсний хүчиллэг чанар, 3) Бордооны элемент, 4) Бордох, 5) Бордолт сайжруулах, 6) Оройг танах, 7) Хиймэл аргаар тоос хүртээх, 8) Цэцэг танах, Жимс танах, 9) Мөчрийг хэлбэржүүлэх, танах, 10) Уутлах, 11) Ургац хураах, 12) Үрслэг мод үржүүлэх, үйлдвэрлэх

2. Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй

Газар тариалангийн мэргэжлийг дагалдах аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар дараах зүйлсийн тухай.

1) Ажлаа эхлүүлэхээс өмнө аюулгүйн төхөөрөмж зэрэгт үзлэг хийх арга
2) Газар тариалангийн мэргэжилд шаардагдах эмхлэх, цэгцлэх ажил
3) Газар тариалангийн мэргэжлийн ажлын зориулалтын тоног төхөөрөмж болон эргэн тойрныхоо аюулгүй байдлыг шалгах арга
4) Хамгаалалтын хэрэгсэл зэргийг хэрэглэх, хувцаслалтын аюулгүй байдлын үзлэг
5) Аюулгүйн төхөөрөмжийг ашигласан аюулгүй ажиллагаа
6) Хөдөлмөрийн эрүүл ахуйн үүднээс хор хөнөөлөөс хамгаалах
7) Хэвийн бус үед авах анхан шатны арга хэмжээ болон дүрвэж зайлах

3. Тутаргын тариалан

(1) Таримал ургамал тариалалтын онцлог

Таримал ургамлын нэр төрөл, тариалалтын хэлбэрийн онцлогийн тухай.

(2) Тариалалтын орчин

Тариалалтын орчны талаар дараах зүйлсийн тухай.

1) Температур, 2) Нарны гэрэл (урт өдөр), 3) Ус, 4) Шим тэжээл, 5) Хөрс

(3) Бүрэгч материал

Бүрэгч материал болох гялгар хальсны тухай.

(4) Бусад байгууламж, тоног хэрэгсэл

Үрслэг хийхэд зориулсан хүлэмжийн тухай.

(5) Өвчин, хортон шавьж, хогийн ургамлаас урьдчилан сэргийлэх

Өвчин, хортон шавьж, хогийн ургамлаас урьдчилан сэргийлэх тухай.

(6) Ургац хураах

Ургац хураах тухай.

4. Тариалан эрхлэх, хүнсний ногоо

(1) Таримал ургамал тариалалтын онцлог

Таримал ургамлын нэр төрөл, тариалалтын хэлбэрийн онцлогийн тухай.

(2) Тариалалтын орчин

Тариалалтын орчны талаар дараах зүйлсийн тухай.

1) Температур, 2) Нарны гэрэл (урт өдөр), 3) Ус, 4) Шим тэжээл, 5) Хөрс

(3) Бүрэгч материал

Бүрэгч материал болох гялгар хальсны тухай.

(4) Бусад байгууламж, тоног хэрэгсэл

Туннель, хучлага, хөргөх байгууламжийн тухай.

(5) Өвчин, хортон шавьж, хогийн ургамлаас урьдчилан сэргийлэх

Өвчин, хортон шавьж, хогийн ургамлаас урьдчилан сэргийлэх тухай.

(6) Ургац хураах

Ургац хураах тухай.

5. Хүлэмжинд цэцэг, нарийн ногоо, жимс тариалах

(1) Таримал ургамал тариалалтын онцлог

Таримал ургамлын нэр төрөл, тариалалтын хэлбэрийн онцлогийн тухай.

(2) Байгууламжийн төрөл ба бүтэц

Байгууламжийн төрөл ба бүтцийн талаар дараах зүйлсийн тухай.

1) Төрөл, ерөнхий бүтэц, 2) Шилэн хүлэмж, 3) Хуванцар байшин,

4) Борооны хамгаалалттай байшин,

5) Дан барилгын төрөл, Залгаа барилгын төрөл

(3) Бүрэгч материал

Байгууламжийн бүрэгч материалын талаар дараах зүйлсийн тухай.

1) Шил, 2) Нэхмэл биш даавуу, 3) Гялгар хальс,

4) Био задралд ордог бүрэгч материал

(4) Дагалдах тоног хэрэгсэл, тоног төхөөрөмж

Дагалдах тоног хэрэгсэл, тоног төхөөрөмжийн талаар дараах зүйлсийн тухай.

1) Халаалтын төхөөрөмж, 2) Агааржуулалтын төхөөрөмж,

3) Нүүрстөрөгчийн давхар ислийн үүсгүүр,

4) Өвчин, хортон шавьжнаас урьдчилан сэргийлэх төхөөрөмж,

5) Услах төхөөрөмж, 6) Тэжээлийн уусмалын тариалалтын төхөөрөмж

(5) Орчны хяналт

Байгууламжийн доторх орчны хяналтын талаар дараах зүйлсийн тухай.

1) Температур, 2) Нарны гэрэл, 3) Ус, 4) Чийгшил, 5) Орчны нэгдсэн хяналт

(6) Тэжээлийн уусмалын тариалалт

Тэжээлийн уусмалын тариалалтын арга болон тариалах хөрсний тухай.

(7) Бусад байгууламж, тоног хэрэгсэл

Туннель, хучлага, хөргөх байгууламжийн тухай.

(8) Өвчин, хортон шавьж, хогийн ургамлаас урьдчилан сэргийлэх

Өвчин, хортон шавьж, хогийн ургамлаас урьдчилан сэргийлэх тухай.

(9) Ургац хураах

Ургац хураах тухай.

6. Жимсний мод

(1) Таримал ургамал тариалалтын онцлог

Жимсний модны амьдрал, нэг жилийн өсөлтийн онцлогийн тухай.

(2) Сорт

Жимсний модны сорт болон тус бүрийнх нь ургац хураах үеийн тухай.

(3) Үрслэг мод үйлдвэрлэх

Үрслэг мод үйлдвэрлэх болон залгаас мод залгах аргын тухай.

(4) Тариалалтын хяналт

Жимслэхэд хяналт тавих, цэцэг болон жимс танах, мөчрийг хэлбэржүүлэх болон танах зэрэг хяналтын тухай.

(5) Бүрэгч материал, ургамлын өсөлтийг зохицуулагч бодис

Бүрэгч материал болох гялгар хальс, ургамлын өсөлтийг зохицуулагч бодисын тухай.

(6) Байгууламж, тоног хэрэгсэл

Усалгаа, хучлага, хадгалах байгууламжийн тухай.

(7) Өвчин, хортон шавьж, хогийн ургамлаас урьдчилан сэргийлэх, жимсний модны цэцэрлэгийн хяналт

Өвчин, хортон шавьж, хогийн ургамлаас урьдчилан сэргийлэх, жимсний модны цэцэрлэгийн хяналтын тухай.

(8) Ургац хураах, хадгалах

Жимсний ургац хураах, хадгалах тухай.

7. Тус баримт бичгийг хэрэгжүүлэх

Хөдөө аж ахуйн ур чадварын түвшин тогтоох шалгалт (Газар тариалангийн ерөнхий мэдлэг)-ын “Онолын шалгалт”-ын даалгаврын агуулгын хүрээг хэрэгжүүлэхдээ, Япон хэлээр боловсруулсан эх хувийг үндэслэн хэрэгжүүлнэ.

Хөдөө аж ахуйн ур чадварын түвшин тогтоох шалгалт (Газар тариалангийн ерөнхий мэдлэг)-ын “Практик шалгалт”-ын даалгаврын агуулгын хүрээ, Монгол хэлний хэвлэл

Үндэсний Хөдөө Аж Ахуйн Танхим

Хөдөө аж ахуйн ур чадварын түвшин тогтоох шалгалтын Хэрэг эрхлэх газар

1. Тутаргын тариалан

(1) Хөрсний ажиглалт

- Багаж хэрэгсэл ашиглан, хөрсний хүчиллэг чанарыг хэмжих.

(2) Бордоотой харьцах

- Бордоог ялгах.
- Бордооны төлөвлөлт, бордох.

(3) Үртэй харьцах

- Боловсруулсан үрийг ялгах.

(4) Материал, тоног төхөөрөмжтэй харьцах

- Бүрэгч материалын хэрэглэх зорилгыг ойлгох, ялгах.

(5) Тариалалтанд хамаарах ажил

- Шилжүүлэн суулгах, ургац хураах.

(6) Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй

- Урьдчилан сэргийлэх багаж зэргийн үзлэг, хамгаалалтын хувцас өмсөх, эмийн бодис цацсаны дараах ажил.
- Хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж зэргийн үзлэг, аюулгүй ажиллагаа.
- Цахилгааны тэжээл, шингэн шатахууны аюулгүй ажиллагаа.
- Химийн бодис шингэлэх, хадгалах.
- Шүршигчийн аюулгүйн үзлэг.

2. Тариалан эрхлэх, хүнсний ногоо

(1) Хөрсний ажиглалт

- Хөрсний зонхилох төрөл.
- Багаж хэрэгсэл ашиглан хөрсний хүчиллэг чанарыг хэмжих.

(2) Бордоотой харьцах

- Бордоог ялгах.
- Бордооны төлөвлөлт, бордох.

(3) Үртэй харьцах

- Үрийг ялгах ба хэмжих.
- Гэрэлд соёолдог үр болон харанхуйд соёолдог үрийг ялгах.

(4) Материал, тоног төхөөрөмжтэй харьцах

- Бүрэгч материалын хэрэглэх зорилгыг ойлгох, ялгах.

- (5) Тариалалтанд хамаарах ажил
 - Үр суулгах, усалгаа.
 - Таримал ургамлын өсөлтийн онош.
 - Үрслэг шилжүүлэн суулгах.
- (6) Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй
 - Урьдчилан сэргийлэх багаж зэргийн үзлэг, хамгаалалтын хувцас өмсөх, эмийн бодис цацсаны дараах ажил.
 - Хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж зэргийн үзлэг, аюулгүй ажиллагаа.
 - Цахилгааны тэжээл, шингэн шатахууны аюулгүй ажиллагаа.
 - Химийн бодис шингэлэх, хадгалах.
 - Шүршигчийн аюулгүйн үзлэг.

3. Хүлэмжинд цэцэг, нарийн ногоо, жимс тариалах

- (1) Хөрсний ажиглалт
 - Хөрсний зонхилох төрөл.
 - Багаж хэрэгсэл ашиглан хөрсний хүчиллэг чанарыг хэмжих.
- (2) Бордоотой харьцах
 - Бордоог ялгах.
 - Бордооны төлөвлөлт, бордох.
- (3) Орчны хяналт
 - Температур, чийгшил хэмжигчтэй харьцах.
 - Хамгийн өндөр температур, хамгийн бага температур, одоогийн температурыг хэмжих.
- (4) Материал, тоног төхөөрөмжтэй харьцах
 - Бүрэгч материал, тоног төхөөрөмжтэй харьцах.
 - Бүрэгч материалын хэрэглэх зорилгыг ойлгох, ялгах.
- (5) Тариалалтанд хамаарах ажил
 - Үрслэг хийх аргыг ялгах.
 - Таримал ургамлын өсөлтийн онош.
 - Үрслэг шилжүүлэн суулгах, эсвэл үр суулгах.
- (6) Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй
 - Урьдчилан сэргийлэх багаж зэргийн үзлэг, хамгаалалтын хувцас өмсөх, эмийн бодис цацсаны дараах ажил.
 - Хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж зэргийн үзлэг, аюулгүй ажиллагаа.
 - Цахилгааны тэжээл, шингэн шатахууны аюулгүй ажиллагаа.
 - Химийн бодис шингэлэх, хадгалах.

4. Жимсний мод (Мөнх ногоон жимсний мод ба навчит жимсний мод)

- (1) Хөрсний ажиглалт
 - Хөрсний зонхилох төрөл.
 - Багаж хэрэгсэл ашиглан хөрсний хүчиллэг чанарыг хэмжих.
- (2) Бордоотой харьцах

- Бордоог ялгах.
 - Бордооны төлөвлөлт, бордох.
- (3) Үр, үрслэг модтой харьцах
- Үртэй харьцах, үрслэг мод (залгаас мод орно) үйлдвэрлэх.
 - Тагнайлдаж залгах.
 - Суурь залгуурга болон залгаас мөчрийг тааруулах.
- (4) Тариалалтанд хамаарах ажил
- 1) Жимсний модны талаар нийтлэг.
 - Жимс танах.
 - Жимслэлтийн төлвийн талаар ойлгох, танах үндсэн арга.
 - 2) Навчит жимсний мод
 - Тохирох цаг үеийг нь дүгнэн тогтоож, хиймэл аргаар тоос хүртээх, уутлах, сойж уях, ургац хураах.
 - 3) Мөнх ногоон жимсний мод
 - Тохирох цаг үеийг нь дүгнэн тогтоож, ургац хураах.
- (5) Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй
- Урьдчилан сэргийлэх багаж зэргийн үзлэг, хамгаалалтын хувцас өмсөх, эмийн бодис цацсаны дараах ажил.
 - Хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж зэргийн үзлэг, аюулгүй ажиллагаа.
 - Цахилгааны тэжээл, шингэн шатахууны аюулгүй ажиллагаа.
 - Химийн бодис шингэлэх, хадгалах.
 - Шүршигчийн аюулгүйн үзлэг.
5. Тус баримт бичгийг хэрэгжүүлэх
- Хөдөө аж ахуйн ур чадварын түвшин тогтоох шалгалт (Газар тариалангийн ерөнхий мэдлэг)-ын “Практик шалгалт”-ын даалгаврын агуулгын хүрээг хэрэгжүүлэхдээ, Япон хэлээр боловсруулсан эх хувийг үндэслэн хэрэг

**Хөдөө аж ахуйн ур чадварын түвшин тогтоох шалгалт
Япон хэлний чадвар шалгах, үнэлгээ хийх агуулгын хүрээ
(Газар тариалан, Мал аж ахуй нийтлэг)
Монгол хэлний хэвлэл**

Үндэсний Хөдөө Аж Ахуйн Танхим

Хөдөө аж ахуйн ур чадварын түвшин тогтоох шалгалтын Хэрэг эрхлэх газар

1. Япон хэлний чадвар шалгах, үнэлгээ хийх агуулга

Япон хэл дээр өгөгдсөн хөдөө аж ахуйн ажлын агуулга зэргийн сонсгол, ойлгоц.

2. Япон хэлний чадвар шалгах, үнэлгээ хийх агуулгын хүрээ ба стандарт

1) Тоо

Юмны үнэ, цаг минут, огноо зэрэг тоо агуулсан үндсэн хэллэгийн сонсгол, ойлгоц.

2) Хэллэг

Мэндчилгээний хэллэг болон үндсэн нэр үг, үйл үг, тэмдэг нэр, дайвар үг зэргийг агуулсан богино өгүүлбэрийн сонсгол, ойлгоц.

3. Тус баримт бичгийг хэрэгжүүлэх

Хөдөө аж ахуйн ур чадварын түвшин тогтоох шалгалтын Япон хэлний чадвар шалгах, үнэлгээ хийх агуулгын хүрээг хэрэгжүүлэхдээ, Япон хэлээр боловсруулсан эх хувийг үндэслэн хэрэгжүүлнэ.